

**“НООЛУУР” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
(2019 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл		
1.	“Ноолуур” хөтөлбөр (2018-2021) Засгийн газрын 2018 оны 47 дугаар тогтоолоор батлагдсан.	Хөтөлбөрийн зорилго: Ноолуурын бүрэн боловсруулалтын түвшинг 60 хувьд хүргэж, байгаль орчинд ээлтэй эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлж, ноолууран бүтээгдэхүүний олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.		
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын болон орон нутгийн төсөв Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт Гадаадын зээл, тусламж ЗГ-ын гадаа, дотоод үнэт цаас Бусад эх үүсвэрээс бүрдэнэ.		
3.	Хэрэгжүүлэгч байгууллага	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн яам, Гадаад харилцааны яам, БОАЖЯ, Монгол Улсын Хөгжлийн Банк, Монголын ноос, ноолуурын холбоо, олон улсын төсөл /ШХА-ийн Ногоон алт, малын эрүүл мэнд төсөл, АХБ-ны Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл, Дэлхийн банкны Экспортыг дэмжих төсөл, НҮБ-ын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл/, үйлдвэрлэгчид, Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн		
4	Хэрэгжих хугацаа	I үе шат 2018-2019 он II үе шат 2020-2021 он		
4.	Хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд шаардлагатай эрх зүй, хөрөнгө оруулалт, татварын таатай, тогтвортой орчинг бүрдүүлэх; Зорилт 2. Ямааны үүлдэр угсаа болон түүхий эдийн бэлтгэл, ноолуурын чанарыг сайжруулах; Зорилт 3. Ноолуурын бүрэн боловсруулалтын түвшнийг үе шаттай ахиулж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх; Зорилт 4. Байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, зорилтот зах зээлд чиглэсэн ээлтэй, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг хөгжүүлэх; Зорилт 5. Салбарын хүний нөөцийг эрэлт, шаардлагад тулгуурлан сургаж, мэргэшүүлэх замаар үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх.		
5.	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал, сая.төг)	Нийт- 973,283.0 үүнээс: -Улсын төсөв – 72,846.0 -МУХБанк(хөнгөлөлттэй зээл) -500,000.0 -Гадаадын төсөл, хөтөлбөрөөс- 400,437.0	
2019 онд: Үүнд		Төсөв (сая.төг)	Гүйцэтгэл (сая.төг)	Хувь (%)
Улсын төсөв		15,201.0	100.6	0.7
МУХБ-с ААН-д олгосон зээл		100,000.0	86,900.0	86.9
Гадаадын төслөөр		52,142.0	919.6	1.8
2019 оны гүйц	167,343.0	87,920.2	52.5%	
6.	Нэгдүгээр үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (2018-2019 онд)	Нийт түүхий эдийн 40 хувийг дотоодын үйлдвэрийн хэрэгцээнд авч, ноолуурын үйлдвэрлэл, худалдаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох, аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн оновчтой дэмжлэг үзүүлэх замаар үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, бүрэн боловсруулалтын түвшинг ахиулах, кластерыг дэмжих, брэндийг таниулах, түүхий эдийн чанар, бэлтгэлийн тогтолцоог сайжруулна.		

<p>1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүү, хөрөнгө оруулалт, татварын таатай, тогтвортой орчинг бүрдүүлэх.</p>	<p>Ноолууран эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх зорилго бүхий эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын сан байгуулах, 300 хүртэлх тэрбум төгрөгийн тогтмол эх үүсвэрийг бүрдүүлэх эрх зүйн орчныг боловсруулах.</p> <p>Монгол банк, МУХБ-тай хамтран ажиллаж, 200 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэрийг бүрдүүлсэн. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх хүрээнд үйлдвэрлэгчдэд МУХБ-ны эх үүсвэрээр зээл олгохоор ХХААХҮЯ, МУХБ-ны хооронд 2018.03.13-ны өдөр 180313/06-070 дугаар бүхий “Ноолуур хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий нөхцөл тохирох гэрээ” –г байгуулж, нийт 20 үйлдвэрт 188.2 тэрбум төгрөгийн, 2019 онд 300 тэрбум төгрөгийн зээл олгох МУХБ-ны удирдах зөвлөлийн шийдвэр гарч, 12 үйлдвэрт 86.9 тэрбум төгрөгийн зээлийг эргэлтийн хөрөнгийн зориулалтаар олгосон.</p> <p>АХБ-ны Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн “Нэмэлт санхүүжилт” төслөөс 3 үйлдвэрт 3.89, 2019 онд 2 үйлдвэрт 8.2 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 7%-ийн хүүтэйгээр хөрөнгө оруулалтад зориулан олгосон.</p> <p>Үр дүн: Ноолуур боловсруулах салбарын түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 25.2 хувь, суурь түвшинд буюу 2014 онд 11.5 хувь байсан бол 2018 онд 35.8, 2019 онд 36.0 хувьд хүрсэн байна.</p> <table border="1" data-bbox="639 685 1481 987"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th> <th>2014 он (суурь)</th> <th>2015 он</th> <th>2016 он</th> <th>2017 он</th> <th>2018 он</th> <th>2019 он</th> <th>2019/2018 (%)</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Ноолуур бэлтгэл, тн</td> <td>6,700</td> <td>7,700</td> <td>8,300</td> <td>9,000</td> <td>9,600</td> <td>9500</td> <td>98.9</td> </tr> <tr> <td>Бэлэн бүтээгдэхүүнд орсон т/эдийн хэмжээ, тн</td> <td>770</td> <td>900</td> <td>1,100</td> <td>1,270</td> <td>2,400</td> <td>2,420</td> <td>100.8</td> </tr> <tr> <td>Нийт т/эдэд эзлэх хувь, %</td> <td rowspan="2">11.5</td> <td>11.7</td> <td>13.3</td> <td>14.1</td> <td>25.0</td> <td>25.2</td> <td>100.8</td> </tr> <tr> <td>Суурь онтой харьцуулахад эзлэх хувь, %</td> <td>13.4</td> <td>16.4</td> <td>19.0</td> <td>35.8</td> <td>36.0</td> <td>100.6</td> </tr> </tbody> </table> <p>*Эх сурвалж: Монголын ноос, ноолуурын холбооноос гаргасан судалгаанаас авав.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100 %</p> <p>Ноолуурын бэлтгэл, боловсруулалтын үе шат бүрт аж ахуйн нэгжүүд хоршин ажиллах чиглэлээр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах</p> <p>Ноолуурын анхан шатны боловсруулалтыг төр, хувийн хэвшлийн хяналттай болгох чиглэлээр УИХ-д өргөн баригдаад байгаа “Зөвшөөрлийн тухай” хуулийн төсөлд санал боловсруулж хүргүүлэв.</p> <p>УИХ-аар 2019 оны 3 дугаар сард баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.1.4 заалтад “ноос, ноолуур”-ыг нэмж оруулсан. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь ноос, ноолуурын үйлдвэрүүдэд ялангуяа кластераар ажиллаж буй үйлдвэрүүдэд татварын таатай орчныг бий болгож байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>Ноолуурын бэлтгэл, боловсруулалтын үе шат бүрт аж ахуйн нэгжүүд хоршин ажиллах чиглэлээр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах.</p> <p>Ноолуурын анхан шатны боловсруулалтыг төр, хувийн хэвшлийн хяналттай болгох чиглэлээр УИХ-д өргөн баригдаад байгаа “Зөвшөөрлийн тухай” хуулийн төсөлд санал боловсруулж хүргүүлэв. УИХ-аар 2019 оны 3 дугаар сард баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.1.4 заалтад “ноос, ноолуур”-ыг нэмж оруулсан. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь ноос, ноолуурын үйлдвэрүүдэд ялангуяа кластераар ажиллаж буй үйлдвэрүүдэд татварын таатай орчныг бий болгож байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>1.4. Борлуулалт, маркетингийн цогц арга хэмжээг хөгжүүлж, гадаад худалдааг хөнгөвчлөх, өргөжүүлэх цогц арга хэмжээ авах; (Тайлант 2019 онд: Худалдаа ба хөрөнгө оруулалтын Замын зураг боловсруулсан байна.) Худалдааг хөнгөвчлөх зорилгоор Дэлхийн банкны санхүүжилтээр ГХЯ-наас Монгол улсын төвийн эдийн засгийн коридорын үнэлгээг хийлгэсэн байна. Мөн Дэлхийн худалдааны байгууллага /ИТС/-ын санхүүжилтээр “Худалдаа ба хөрөнгө оруулалтын замын зураг” төслөөс Ноос, ноолуурын салбарын худалдаа, хөрөнгө оруулалтын замын зураг боловсруулах судалгаа хийсэн. Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр /НҮБХХ/-ийн “Ноолуурын тогтвортой өртгийн сүлжээ” төслийн хүрээнд Монгол улсад байгаль орчинд ээлтэй ноолуур үйлдвэрлэлийн чиглэлээр богино болон дунд хугацаанд авч хэрэгжүүлэх талуудын хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлсон Замын зураг боловсруулах ажлыг гүйцэтгэсэн ба тус ажлыг гүйцэтгэхэд ХХААХҮЯ-аас арга зүйн зөвлөмж өгч хамтран ажиллав.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p>	Үзүүлэлт	2014 он (суурь)	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2019/2018 (%)	Ноолуур бэлтгэл, тн	6,700	7,700	8,300	9,000	9,600	9500	98.9	Бэлэн бүтээгдэхүүнд орсон т/эдийн хэмжээ, тн	770	900	1,100	1,270	2,400	2,420	100.8	Нийт т/эдэд эзлэх хувь, %	11.5	11.7	13.3	14.1	25.0	25.2	100.8	Суурь онтой харьцуулахад эзлэх хувь, %	13.4	16.4	19.0	35.8	36.0	100.6
Үзүүлэлт	2014 он (суурь)	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2019/2018 (%)																																	
Ноолуур бэлтгэл, тн	6,700	7,700	8,300	9,000	9,600	9500	98.9																																	
Бэлэн бүтээгдэхүүнд орсон т/эдийн хэмжээ, тн	770	900	1,100	1,270	2,400	2,420	100.8																																	
Нийт т/эдэд эзлэх хувь, %	11.5	11.7	13.3	14.1	25.0	25.2	100.8																																	
Суурь онтой харьцуулахад эзлэх хувь, %		13.4	16.4	19.0	35.8	36.0	100.6																																	

		<p>1.5. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, химийн болон бусад туслах материалыг импортлох үйл ажиллагааг татварын бодлогоор дэмжих асуудлыг судалж боловсруулах.</p> <p>ЖДҮ-ийн зориулалттай үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг импортлох гаалийн татвараас чөлөөлөх тухай 168-р тогтоолыг сунгахтай холбогдуулан хуулийн төслийн үзэл баримтлал, холбогдох бичиг баримтыг боловсруулан санал авахаар Хууль зүйн яам, Сангийн яаманд хүргүүлсэн. Шинээр батлагдсан Татварын хуультай зэрэгцэж дээрх тогтоолыг сунгах боломжгүй гэсэн хариуг өгсөн. ХШҮ-70%</p> <p>1.6. Угаасан ноолуурын экспортыг багасгах чиглэлээр тарифын болон тарифын бус хязгаарлалт хийх асуудлыг судлан шийдвэрлэх; (Тайлант 2019 онд: Угаасан ноолуурын экспортын хэмжээ 4500 тн хүртэл бууруулж, самнасан ноолуурын экспортыг 800 тн хүртэл нэмэгдүүлнэ.) “Ямааны ноолуурын үйлдвэрлэл худалдаанд” мөрдөх техникийн зохицуулалтын төсөл, ЗГ-ын тогтоолын төсөл болон бусад материалуудыг боловсруулан яамд болон холбогдох газруудаас санал авч, ЗГХЭГ-т хүргүүлсэн. СХГ нь хуульд заасан үүргийн дагуу уг техникийн зохицуулалтыг ДХБ-д мэдэгдсэн, харну хүлээж байна.</p> <table border="1" data-bbox="639 685 1473 801"> <thead> <tr> <th rowspan="2">Үзүүлэлт</th> <th colspan="2">2019 оны</th> <th rowspan="2">Биелэлт %</th> <th rowspan="2">2019 % 2018</th> <th rowspan="2">2019 % 2017</th> </tr> <tr> <th>Төл</th> <th>Гүй</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Угаасан ноолуур, тн</td> <td>4500</td> <td>5688.7</td> <td>126.4</td> <td>107.6</td> <td>105.2</td> </tr> <tr> <td>Самнасан ноолуур, тн</td> <td>800</td> <td>507.2</td> <td>63.4</td> <td>80.5</td> <td>88.8</td> </tr> </tbody> </table> <p>Тайлант онд угаасан ноолуурын экспортын хэмжээ төлөвлөгөөнөөс 1188,7 тн буюу 26.4 хувиар өсч, самнасан ноолуур 292.8 тн-оор буюу 36.6 хувиар буурсан сөрөг үзүүлэлттэй гарч байна. ХШҮ-0%</p> <p>1.7. Ноолуурын боловсруулалтын түвшин, өртөг шингэсэн байдлаас хамаарч 3-аас доошгүй жилийн хугацаатай эргэлтийн хөрөнгийн болон хөнгөлөлттэй нөхцөлтэй, хөрөнгө оруулалтын урт хугацаатай зээлийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах. (Тайлант 2019 онд: 20-аас доошгүй үйлдвэр эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгосон байна.) МУХБ нь нийт 12 үйлдвэрт 86.9 тэрбум төгрөгийн зээлийг эргэлтийн хөрөнгийн зориулалтаар олгосон. -АХБ-ны “Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжил” төслийн “Нэмэлт санхүүжилт” төслөөс 2 үйлдвэрт 8.2 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 7%-ийн хүүтэйгээр хөрөнгө оруулалтад зориулан олгосон. Үр дүн: 2019 онд самнах үйлдвэрлэлийн хүчин чадал 40.0%, ээрэх үйлдвэрлэлийнх 35.0%, сүлжих үйлдвэрлэлийнх 60.0%-иар өссөн байна. Өмнөх онтой харьцуулахад самнах үйлдвэрлэлийн хүчин чадал 6.2, ээрэх үйлдвэрлэлийнх 6.4, сүлжих үйлдвэрлэлийнх 17.3 хувиар тус тус нэмэгдсэн байна. ХШҮ-100%</p> <p>1.8. Ноолуурын ангилж үйлдвэрт тушаасан малчинд чанараас хамаарсан нэг удаагийн урамшуулал олгох асуудлыг судалж шийдвэрлэх. (Тайлант 2019 онд: Цахим системд бүртгэлжүүлэх ажлыг 3-аас доошгүй суманд туршсан байна.) НҮБХХ-ийн “Ноолуурын тогтвортой өргийн сүлжээ” төслийн хүрээнд Хэнтий аймгийн Норовлин сум, Дорнод аймгийн Цагаан-овоо, Баян-уул суманд ноолууран түүхий эдийг блокчейн технологид суурилсан цахим системд бүртгэлжүүлэн мөшгих тогтолцоог туршиж хэрэгжүүлсэн. ШХА-ын Ногоон Алт Малын эрүүл мэнд төслийн 35 сая төгрөгийн санхүүжилтээр Монголын Бэлчээр Ашиглагчдын Нэгдсэн холбооноос 2019 оны хагас жилд төсөл хэрэгжиж буй 18 аймгаас сонгон загвар 28 сумын хоршоо болон СБАХ-аас бэлтгэсэн түүхий эдийн бэлтгэлийг RMTS цахим системд оруулсан. ХШҮ-100%</p>	Үзүүлэлт	2019 оны		Биелэлт %	2019 % 2018	2019 % 2017	Төл	Гүй	Угаасан ноолуур, тн	4500	5688.7	126.4	107.6	105.2	Самнасан ноолуур, тн	800	507.2	63.4	80.5	88.8
Үзүүлэлт	2019 оны			Биелэлт %	2019 % 2018				2019 % 2017													
	Төл	Гүй																				
Угаасан ноолуур, тн	4500	5688.7	126.4	107.6	105.2																	
Самнасан ноолуур, тн	800	507.2	63.4	80.5	88.8																	
	<p>Зорилт 1-ийн дундаж үнэлгээ -83.8%</p> <p>2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Ямааны үүлдэр угсаа болон түүхий эдийн бэлтгэл, ноолуурын чанарыг сайжруулах арга хэмжээ авсан байна.</p>	<p>2.1. Ямааны үүлдэр омог, тархац болон ноолуурын шинж чанараас хамаарч, сүргийн оновчтой бүтцийн судалгаа хийсэн байна. Ямааны үүлдэр омог, тархац болон ноолуурын шинж чанараас хамаарч, сүргийн оновчтой бүтцийн судалгааг хийв. ХШҮ-70%</p> <p>2.2. Ноолуурыг чанараар нь ангилан бэлтгэхийн давуу талыг үзүүлсэн сургалт, туршилт явуулсан байна. ШХА-ын Ногоон алт-Малын эрүүл мэнд төслийн 90 сая төгрөгийн санхүүжилтээр Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбооноос 2019 онд баруун бүсийн 7 аймгийн 22 суманд малын гаралтай түүхий эдийг ангилан ялгаж бэлтгэх, чанарыг сайжруулах чиглэлээр 3100 гаруй малчдад танхимын болон практик сургалтыг хийсэн. Азийн хөгжлийн банк /АХБ/-ны Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжлийн Техник туслалцааны төсөл нь Монголын хаан ширхэгтийн чанарт нийцэх түүхий эдийг бэлтгэх технологийн сургалтын 3 модуль боловсруулж, нийт 14 сургалтаар 4 аймгийн 18 хоршоодын 578 малчин,</p>																				

	<p>хоршооны сургагч багш нарыг чадавхжуулсан. НҮБХХ-ийн “Ноолуурын тогтвортой өртгийн сүлжээ” төсөл нь Хэнтий аймгийн Норовлин сум, Дорнод аймгийн Цагаанц-овоо, Баян-уул сумын 6 хоршооны 400 гаруй малчинд ноолуурыг чанараар нь ангилан бэлтгэх, ноолуур бэлтгэлийн ажлыг хэрхэн зохион байгуулах, хоршооны удирдлага зохион байгуулалт, засаглал зэрэг сэдвээр 3 удаагийн сургалтыг Монголын ноос, ноолуурын холбоо, Тогтвортой ноос ноолуурын эвсэл, Сор Кашмир үйлдвэртэй хамтран зохион байгуулсан.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>2.3. Малчид, малчдын хоршоодод зориулсан түүхий эд бэлтгэлийн чиглэлээр сургалтыг 6-аас доошгүй аймагт зохион байгуулсан байна.</p> <p>ХХААХҮЯ-аас ноос, ноолуур, арьс ширэн түүхий эдийг үйлдвэрийн стандарт шаардлагад нийцүүлэн чанартай бэлтгэх тухай видео сургалтын материалыг бэлтгэж, 21 аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газарт хүргүүлэн, малчид, түүхий эд бэлтгэгчдэд зориулсан сургалтыг явуулж, мэдлэгжүүлэх ажлыг хийж байна.</p> <p>Түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, үйлдвэр хоршоодын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор 2019 оны 04 сард “Үйлдвэр-хоршоодын уулзалт”-ыг Улаанбаатар хотод зохион байгуулсан. Уг уулзалтад МННХ, МАШБҮХ, гадаадын донор байгууллагын төлөөлөл, ноос ноолуур, арьс шир, мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, малчдын хоршоодын төлөөлөл 80 гаруй хүн оролцсон. Тус уулзалтаар үйлдвэрлэгчид түүхий эдийн чанарт тавигдах шаардлага, хоршоод бэлтгэн нийлүүлэх боломжтой түүхий эдийн асуудлаар хэлэлцэж, 2019 онд түүхий эд бэлтгэлд хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>2.4. 2 аймагт түүхий эдийг биржээр арилжаалах арга хэмжээ зохион байгуулсан байна.</p> <p>ХААБ-ийн арилжаанд малчид, үйлдвэрлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ХХААХҮЯ, ХААБ ХХК, Сүхбаатар. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын ЗДТГ хамтран “Ноолуурын төвлөрсөн дуудлага худалдаа”-г 2019 оны 03.22-23-нд Сүхбаатар аймгийн төвд, 03.24-нд Хэнтий аймгийн Өмнөдэлгэр суманд зохион байгуулсан. Төвлөрсөн худалдаагаар нэг кг ноолуурын үнэ 138.0 мянган төгрөгт хүрч, 20 гаруй тонн ноолуур арилжсан.</p> <p>Малчид, хоршоо, дотоодын үйлдвэрүүдэд биржээр арилжих бараа, түүхий эдийн захиалгыг авах зорилгоор биржийн арилжааны захиалгын сан /order-mse.mn/-г 2018 онд нэвтрүүлсэн. Энэхүү захиалгын сангаар дамжуулан түүхий эдийн ханшийн мэдээг олон нийтэд цахим орчинд хүргэж, талуудын захиалгыг авч биржийн арилжааг онлайн хэлбэрээр зохион байгуулж байна.</p> <p>ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн арилжааг идэвхжүүлэх, зах зээлийн нэгдсэн дэд бүтцийг сайжруулах зорилгоор Төв аймгийн Аргалтант сум Эмээлт орчимд ХААБ-ийн ложистикийн төв байгуулахаар ажиллаж байна. Уг төв нь УБ хотод ХАА-н гаралтай бараа, түүхий эдийг бэлтгэх, чанарыг тодорхойлох /лаборатори/, тээвэрлэх, хадгалах, даатгах болон биржээр арилжих цогц үйл ажиллагааг явуулах төв байхаар төлөвлөж байна.</p> <p>Тус ложистик төвд биржээр арилжаалсан бараа, түүхий эдийг хадгалах, ложистикийн систем болон хяналтын системээр дамжуулан биет бүтээгдэхүүний арилжааг хөнгөвчлөх, дуудлага худалдааг тогтмол зохион байгуулах, санхүүгийн салбарын бусад оролцогчдыг зах зээлд нэвтрүүлэх боломжийг бий болгох ач холбогдолтой юм.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>2.5. Түүхий эдийн бэлтгэлийг тогтвортой байлгах зорилгоор бэлээр хамгаалах, нөхөн сэргээлт хийх, ойжуулах, усжуулах, хадлан тэжээл бэлтгэх чиглэлээр үйлдвэрлэл эрхлэгчид, малчдын оролцоотой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг дэмжих;</p> <p>ШХА-ын “Ногоон алт-Малын эрүүл мэнд төсөл”-ийн санхүүжилтээр түүхий эдийн бэлтгэлийг тогтвортой байлгах зорилгоор бэлчээр хамгаалах, нөхөн сэргээлт хийх, ойжуулах, усжуулах, хадлан тэжээл бэлтгэх, хоршоог дэмжих, бүтээгдэхүүний гарц нэмэгдүүлэх, бааз суурийг сайжруулах чиглэлээр малчид, орон нутаг, ТББ-ын оролцоотойгоор жижиг төслийг хэрэгжүүлэхээр “Ногоон алт-Малын эрүүл мэнд” төсөл хэрэгжиж буй аймаг, сумдад төслийн саналыг хүргүүлж, дэмжлэг үзүүлж байна. Олон улсын хөдөө аж ахуйн хөгжлийн сангийн санхүүжилттэйгээр “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” нэмэлт санхүүжилт төслийг хэрэгжүүлж байна. Уг төсөлд хамрагдсан Сүхбаатар, Хэнтий, Архангай, Өвөрхангай, Дундговь, Дорнод аймагт 6 өвс, тэжээлийн агуулах саравч, 30 инженерийн хийцтэй гүн өрмийн худаг, 44 бог мал угаалгын ванн тус тус барьж байгуулсан. Мөн “Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө”-г 11 суманд боловсруулах, үлийн оготно устгах тоног төхөөрөмж 122-ыг 18 суманд нийлүүлэх ажлыг хэрэгжүүлсэн. Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй “Тогтвортой тэжээл үйлдвэрлэл” төсөл хэрэгжүүлэхээр баримт бичигт гарын үсэг зурсан.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p>
--	--

		<p>2.6. Малыг эрүүлжүүлэх ажил болон түүхий эдийг боловсруулах явцад ноолуурын ширхэгийг гэмтээхгүйгээр хаг болон бусад хогт хольцын хэмжээг бууруулах, арилгах дэвшилтэт арга ажиллагаа, технологи нэвтрүүлэх. Малын тэмдэглэгээнд Широ будгийг турших, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40%</p>																															
Зорилт 2-ын дундаж үнэлгээ -85.0%																																	
	<p>3-р зорилтын хүрээнд:</p> <p>Хүрэх үр дүн: Ноолуурын бүрэн боловсруулалтын түвшнийг үе шаттай ахиулж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлсэн байна.</p>	<p>3.1. Хувийн хөрөнгө оруулалтаар ээрмэлийн үйлдвэр байгуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэн өргөжүүлэх; (Тайлант 2019 онд: Ээрэх үйлдвэрлэлийн хүчин чадал 1 дахин өссөн байна.) Ноолуурын үйлдвэрлэлд эргэлтийн хөрөнгийн дэмжлэг олгосны үр дүнд: Самнах үйлдвэрлэлийн хүчин чадал 40.0%, ээрэх үйлдвэрлэлийн хүчин чадал 35.0%, сүлжих үйлдвэрийн хүчин чадал 60.0%-иар тус тус өссөн байна. Ноолуурын нийт экспорт 2019 онд өмнөх оноос 6.0 хувиар буюу 24.8 сая.ам доллараар өссөн байна.</p> <table border="1" data-bbox="625 613 1477 869"> <thead> <tr> <th rowspan="2">Үзүүлэлт</th> <th colspan="2">2018 он</th> <th colspan="2">2019 он</th> </tr> <tr> <th>Тоо хэмжээ</th> <th>Үнийн дүн (сая.дол)</th> <th>Тоо хэмжээ</th> <th>Үнийн дүн (сая.дол)</th> </tr> </thead> <tbody> <tr> <td rowspan="3">Экспорт</td> <td>Угаасан ноолуур</td> <td>5286.6 тн</td> <td>251.9</td> <td>5688.7</td> <td>283.3</td> </tr> <tr> <td>Самнасан ноолуур</td> <td>630.2 тн</td> <td>54.9</td> <td>507.2</td> <td>45.3</td> </tr> <tr> <td>Эцсийн бүтээгдэхүүн</td> <td>742.0</td> <td>83.4</td> <td>1148.7</td> <td>87.7</td> </tr> <tr> <td colspan="2">Нийт экспорт</td> <td></td> <td>409.8</td> <td></td> <td>434.6</td> </tr> </tbody> </table> <p>* Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын статистик мэдээллээс авав.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40%</p> <p>3.2. Сүлжмэл, нэхмэлийн жижиг, дунд үйлдвэрүүдийг кластерийн зохион байгуулалтад оруулж бүртгэлжүүлэн ээрмэл утас, туслах материал, загвар дизайны нэгдсэн захиалга, борлуулалтын үйл ажиллагааг эрхлэх ажлыг салбарын мэргэжлийн холбоогоор хариуцуулан гүйцэтгүүлэх. МННХолбоо нь дэргэдээ “Дизайн төв”-ийг 2018 онд байгуулсан ба тус төвөөр дамжуулан сүлжмэлийн жижиг үйлдвэрүүдэд захиалгын дагуу загвар дизайн гаргаж өгөх ажлыг зохион байгуулж байна. МННХ, Италийн худалдааны агентлаг (ИХА), Италийн нэхмэлийн үйлдвэрлэлийн үндэсний холбоо /ИНҮҮХ/ хамтран “Нэхмэлийн технологи дамжуулах төв”-ийг МННХ-ны дэргэд байгуулахад дэмжин ХХААХҮЯ болон Итали улсын Эдийн засаг хөгжлийн яамны хооронд Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. Могол ноос ХХК нь Дундговь, Төв зэрэг аймгууд түүхий эдээ авч, ноос угаах, ээрэх, үйлдвэрээр боловсруулан эцсийн бүтээгдэхүүн гаргаж, ноос үйлдвэрлэлийн кластерийн төрлийг бий болгоод байна. “Могол ноос” ХХК нь 27 сумын түүхий эд бэлтгэн нийлүүлэгч ААН, иргэдэд зориулсан сургалт зохион байгуулж нийт 54 иргэн, ААН хамрагдаж мэргэжил арга зүйн зөвлөмж авсан. Ноосыг кластераар хөгжүүлэх бодлогын хүрээнд Могол ноос ХХК нь ээрмэл утасны үйлдвэрийг түшиглэн 12 сумын 27 иргэний сүлжмэлийн сургалтад хамруулж, мэргэжлийн чадамжийн гэрчилгээ олгосон. “Могол ноос” ХХК нь ноосон пальтоны үйлдвэрийг ашиглалтад оруулан шинээр 34 ажлын байр бий болж 2019 онд 2903 ширхэг пальтог Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, Төв, Увс, Баян-Өлгий, Дундговь, Сэлэнгэ аймагт байгуулсан нэрийн барааны борлуулалтын цэгээр борлуулж, “МОГОЛ” брэндийг ОХУ, Унгар улсын зах зээлд худалдаалж эхэллээ. Ээрмэл утасны үйлдвэрийг түшиглэн Алтанбулаг, Баянхангай, Баяндэлгэр, Баянцогт, Баянчандмань, Өндөрширээт, Бүрэн, Зуунмод, Сэргэлэн, сумдын 11 цех ноосон цамц, майк, өмд, ороолт зэрэг 3500 ш бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлсэн байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p>	Үзүүлэлт	2018 он		2019 он		Тоо хэмжээ	Үнийн дүн (сая.дол)	Тоо хэмжээ	Үнийн дүн (сая.дол)	Экспорт	Угаасан ноолуур	5286.6 тн	251.9	5688.7	283.3	Самнасан ноолуур	630.2 тн	54.9	507.2	45.3	Эцсийн бүтээгдэхүүн	742.0	83.4	1148.7	87.7	Нийт экспорт			409.8		434.6
Үзүүлэлт	2018 он			2019 он																													
	Тоо хэмжээ	Үнийн дүн (сая.дол)	Тоо хэмжээ	Үнийн дүн (сая.дол)																													
Экспорт	Угаасан ноолуур	5286.6 тн	251.9	5688.7	283.3																												
	Самнасан ноолуур	630.2 тн	54.9	507.2	45.3																												
	Эцсийн бүтээгдэхүүн	742.0	83.4	1148.7	87.7																												
Нийт экспорт			409.8		434.6																												
		<p>3.3. Хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд халгуй, чанар, аюулгүйн стандартын шаардлага хангасан ээлтэй бүтээгдэхүүн болон хэрэглээний шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил, инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх (10-аас доошгүй ноолуур боловсруулах үйлдвэрт байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийсэн байна.) ХХААХҮЯ-ны захиалгаар ШУТ сангийн 74.5 сая төгрөгийн санхүүжилтээр Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн “Нэхмэлийн үйлдвэрийн хими технологийн боловсруулалтад хэрэглэдэг зарим материалыг байгалийн гаралтай түүхий эдээр орлуулан хэрэглэх технологийн судалгаа”-г гүйцэтгэсэн. Судалгаагаар ноос, ноолууран түүхий эдийн боловсруулалтад ашиглах ургамлын био бэлдмэлийг гарган авах, технологийг оновчлон, гарган авсан био бэлдмэлээ боловсруулалтад ашигласнаар бүтээгдэхүүнд өнгө гөхөөс гадна бактерийн эсрэг идэвх, хэт ягаан туяаны хамгаалалт үүсэж байгааг баталсан</p>																															

		<p>байна. Ургамлын био бэлдмэлээр ноос, ноолуурт боловсруулалт хийснээр хүний эрүүл мэнд, аюулгүйн стандарт шаардлагыг хангасан шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой ба хүрээлэн буй орчинд халгүй, эрүүл мэндэд эрсдэлгүй технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж бүрдэж байна. STERECCLAB төслийн хүрээнд ноос ноолуур боловсруулах 20 үйлдвэрийн байгаль орчин нийгэмд үзүүлэх нөлөөллийн судалгааг хийсэн. Судалгааны шалгуур үзүүлэлтүүдээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн текстилийн Made in Green OEKO TEX ба GOTS стандартын үзүүлэлтүүдийг сонгон авч нөлөөллийн үнэлгээг хийж, тайлан гаргав.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p>
		<p>3.4. Ноолуурын бэлтгэл, чанар, стандарт, технологийн сургалт, үзэсгэлэн худалдаа, технологи дамжуулалт болон бусад үйлчилгээг мэргэжлийн холбоогоор гэрээгээр гүйцэтгүүлэх, үр дүнг жил бүр дүгнэж үйлдвэрлэгчид, малчдад мэдээлэх.</p> <p>(2019 онд: Монгол экспорт экспо нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан байна.) “Монгол экспорт экспо-2019” дотоодын үзэсгэлэн худалдааг 2019.11.17-21-ний өдрүүдэд Мишээл экспо төвд зохион байгуулав. Үзэсгэлэн худалдаанд арьс шир, ноос ноолуур, хүнс, гоо сайхан, хэвлэл, сав баглаа боодол, дахин боловсруулах, оёдол, модны үйлдвэрлэлийн салбарын 116 үйлдвэрлэгчид оролцлоо. 5 өдрийн үзэсгэлэн худалдаанд 400 гаруй сая төгрөгийн борлуулалт хийлээ. Үзэсгэлэнгээр нийт давхардсан тоогоор 5000 гаруй хүн очиж сонирхон худалдан авалт хийгээд байна. Нэг хүний үзэсгэлэнгээс дундаж худалдан авалт 80.0 мянган төгрөг орчим байв.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p>
Зорилт 3-ын дундаж үнэлгээ -77.5%		
4-р зорилтын хүрээнд: Байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, зорилтот зах зээлд чиглэсэн ээлтэй, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг хөгжүүлэх		<p>4.1.Ноолууран бүтээгдэхүүний хэрэглээний чиг хандлагын мэдээллийн сан бүрдүүлэх, гадаад, дотоодын зах зээлийн тандан судалгааг системтэй дэмжин хөгжүүлэх. (Гадаад, дотоодын зах зээлийн тандан судалгаа хийсэн байна) НҮБХХ-ийн “Ноолуурын тогтвортой өртгийн сүлжээ” төслийн хүрээнд Байгаль орчинд ээлтэй ноолуурын зах зээлийн судалгааг 2019 оны 5 сард хийж гүйцэтгэсэн. Судалгаанд дотоодын болон гадаадын эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид хамрагдсан. Үүнд: Говь, Гоёо, LVMH, Loro Piana, Kering, Channel, Burberry, Johnsons of Elgin, Alex Begg, H&M, M&S, C&A, Inditex, Eileen Fisher зэрэг болно.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>4.2.Монгол ноолуурын өнгө, давуу шинж чанарт тулгуурлан “Монголын Хаан Ширхэгт” брэндийг хөгжүүлж, зах зээлд таниулах, сурталчлах; “Монголын хаан ширхэгт” сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний чанарын стандартыг шинээр боловсруулан СХЗГ-ын ноос, ноолуурын стандартчилалын техникийн хороогоор хэлэлцүүлэн батлуулав.</p> <p>-АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “ХАА Нэмүү өртгийн сүлжээг дэмжих” техник тусалцааны төсөл нь “Монголын Хаан Ширхэгт” /МХШ/ бүтээгдэхүүний чанарт нийцэх түүхий эдийг бэлтгэх технологийн сургалтын 3 модуль боловсруулж, нийт 14 сургалтаар 4 аймгийн 18 хоршоодын 578 малчид, хоршооны сургагч багш нарыг, үйлдвэрлэлийн түвшинд олон улсын стандартад дүйцэх МХШ гэрчлэх тэмдэгт ээрмэл, нэхмэл, сүлжмэлийн чанар, хяналтын болон гүйцэтгэн боловсруулалтын технологийн сургалтын 5 модулийг аж ахуйн нэгж бүрийн онцлогт суурилан боловсруулж, нийт 16 сургалтыг 15 ААН-ийн ажлын байранд зохион байгуулж, нийт 371 ИТА-ыг хамруулав.</p> <p>Сургалт, туршилтын ажлын хүрээнд: “МХШ бүтээгдэхүүний чанарт нийцсэн түүхий эдээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөгжүүлэх” загвар туршилтыг малчдын болон үйлдвэрлэлийн түвшинд хийгээд байна.</p> <p>“Түүхий эдийн ангилалтын загвар туршилт”-ыг явуулах арга зүйг “Бага насны ямааны ноолуурын ангилалт” “Хөх сарлагийн хөөврийн ангилалт” зэрэг 2 төрлийн түүхий эдийн онцлогт тохируулан боловсруулж, туршилтыг Хөвсгөл аймгийн Арбулаг, Алаг-эрдэнэ, Улаан-Уул сумдын малчдын 5 хоршоо, Жинст Мөрөн ХХК-тай хамтран зохион байгуулсан.</p> <p>Туршилтын явцад нийт 86 сургагч багшийг бэлтгэсэн ба сургагч багш нар “Түүхий эдийн чанар, ангилалт”-ын талаар сурсан мэдлэгээ нийт 350 гаруй малчдад зааж сургасан байна.</p> <p>“Бага насны ямааны ноолуурын ангилалт”-ын загвар туршилтад Улаан-уул сум хоршооноос 45 малчин өрх, Арбулаг сумаас 48, Алаг-эрдэнэ сумаас 25 буюу нийт 118 өрх хамрагдаж, ямааны ноолуурыг насаар ангилан ялгаж бэлтгээд хоршоогоор дамжуулан 3 тонн гаруй бага насны ноолуурыг бэлтгэн “Жинст Мөрөн” ХХК компанитай хийсэн гэрээний хүрээнд нийлүүлжээ.</p> <p>“Хөх сарлагийн хөөврийн ангилалт”-ын загвар туршилтад Улаан уул сумын хоршооноос 230 малчин өрх, Арбулаг сумаас 71, Алаг-эрдэнэ сумаас 442 буюу нийт 743 гишүүн малчин өрх хамтран ажилласны дүнд нийт 5 тонн гаруй хөөвөр бэлтгэснээс 1,5 тонн хөх сарлагийн хөөврийг өнгөөр нь тусгайлан ангилан бэлтгэж, тус компанид нийлүүлжээ. “Жинст Мөрөн” ХХК нь түүхий эдийн</p>

		<p>худалдан авалт, анхан шатны тордолт, хадгалах агуулах, тээвэрлэлт болон шаардагдах зардлын хариуцан ажиллаж байна.</p> <p>“Ангилж бэлтгэсэн түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх загвар туршилт”-ын хүрээнд “Жинст Мөрөн” ХХК нь ангилж бэлтгэсэн бага насны ноолуурын анхан шатны боловсруулалтыг “Өгөөж Шим” ХХК, ээрэхийг “Сноү Фиилд” ХХК, сүлжихийг “Мөнхбумууд” ХХК зэрэг компаниудтай кластераар хамтран ажиллах түншлэлийн гэрээ байгуулан “Монголын хаан ширхэгт” бүтээгдэхүүний загвар гаргахаар хамтран ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>4.3. Байгаль орчинд ээлтэй шинэ, дэвшилтэт техник, технологи үйлдвэрлэлд нэвтрүүлж, олон улсын чанар, аюулгүйн стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх; (Ноос, ноолуурын үйлдвэрээс гарч буй технологийн хаягдал усыг эргүүлэн ашиглах судалгаа хийх.)</p> <p>Ноос ноолуур, арьс ширний үйлдвэрүүдийн хаягдал усыг эргүүлэн ашиглах саарал усны стандартын төслийг боловсруулан СХГ-т хүргүүлсэн. ЗГ-ын 73-р тогтоолын хэрэгжилтийн хүрээнд үйлдвэрээс гарч буй бохир усны стандартыг хангуулах, байгальд ээлтэй шинэ технологийг мөрдүүлэх зорилгоор ноосны 20 үйлдвэр, арьс ширний 50, хүнсний 10 үйлдвэрийг оролцуулан БХБЯ, ШУТИС-ын БАС-тай хамтарсан хэлэлцүүлэг тус тус зохион байгуулж, шинэ технологийн танилцуулга хийв. Мөн шинэ цэвэрлэх байгууламж ашиглалтад оруулахтай холбоотой урьдчилсан цэвэрлэх байгууламжийн /Харгиа/ нөхөн сэргээлт, хөрөнгө оруулалтын талаар НЗДТГ, БХБЯ-тай хамтран ажиллах санамж бичигт оруулсан.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40%</p> <p>4.4 "Олон улсын зах зээлд ноолууран бүтээгдэхүүнийг таниулах, сурталчлах зорилгот үзэсгэлэн яармаг, бизнес форумд оролцох, зохион байгуулах; (Экспортын өсөлт 20%-аас багагүй байна.)</p> <p>АНУ-ын нийслэл Вашингтон хот дахь Дэлхийн банкны үндсэн цогцолборт “Монголын өв соёлын өдрүүд”, “Монголд үйлдвэрлэв-2019” үзэсгэлэн худалдаа, бизнес форумыг Экспорт Олон улсын худалдааны төв, ХХААХҮЯ, ГХЯ, ЖПҮХС, ХААБ, Монгол Улсаас АНУ-д суугаа ЭСЯ хамтран зохион байгууллаа. Тус бизнес форумын үеэр АНУ, МУЗГазар хоорондын худалдаа хөрөнгө оруулалтын VI хуралдаан болж, гуравдагч хөршийн бодлого, оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний экспортын асуудал зэрэг үйлдвэрлэгчдэд тулгамддаг асуудлыг тодорхой түвшинд авч хэлэлцсэн. МННХ нь Япон улсын “Fashion World Tokyo” болон АНУ-ын “Coterie” олон үзэсгэлэнд компаниудыг зохион байгуулж оролцуулсан.</p> <p>“Монголын хаан ширхэгт” ноолуурын олон улсын форумыг зохион байгуулж, тохирлын баталгаатай, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд халгүй, чанар аюулгүйн стандартын шаардлага хангасан ээлтэй бүтээгдэхүүн хөгжүүлэх, улмаар олон улсын зах зээлд танигдсан нэр хүндтэй бренд болгох үйл ажиллагаа эхлүүлээ. Тус арга хэмжээнд 17 улсын Элчин сайдын яамд, үндэсний үйлдвэрлэгчид, малчдын хоршооны төлөөлөл, судлаачид, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын худалдан авагчид, төсөл, хөтөлбөрүүдийн төлөөлөл нийт 350 гаруй хүн оролцсон.</p> <p>Нэхмэлийн салбарын нийт экспортын хэмжээ 2019 оны дүнгээр 434.6 сая. ам долларт хүрч, өмнөх онтой харьцуулахад 6.0 хувиар өссөн байна. Экспортын хэмжээ төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй шалтгааныг авч үзэхэд: ХБ-наас түүхий эд бэлтгэлийн хугацаа өнгөрсний дараа /6 сарын сүүлийн хагаст/ зээл олгосон, хятад ченжүүд ноолуурыг өндөр үнээр авснаас шалтгаалж дотоодын үйлдвэрүүд түүхий эдийн хомсдолд орсон нь нөлөөлсөн байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40%</p> <p>4.5. Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн (ХҮСХХ) нэхмэлийн сорилт, судалгааны лабораторийг шинэчлэн чадавхжуулж, олон улсын түвшний сорилт баталгаажуулалт хийх түвшинд хүргэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах; (Лабораторийн орчны чийглэг, агааржуулалтыг тохируулах төхөөрөмжийг авахад дэмжлэг үзүүлсэн байна.)</p> <p>АХБ-ны санхүүжилтээр Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнд лабораторийн орчны чийглэг, агааржуулалтыг тохируулах 121.4 сая төгрөгийн үнэ бүхий төхөөрөмжийг нийлүүлэх нээлттэй тендерт шалгарсан “NEW BEST CHOICE” компани нь гэрээний дагуу төхөөрөмжийг нийлүүлж, угсралт суурилуулсан. Мөн тус хүрээлэн нь БНХАУ-аас ус нэрэх, хатаах аппарат, дулааны шинж чанар тодорхойлогч багаж, багц үсний дацны төхөөрөмж, зузаан хэмжигч тоног төхөөрөмжийг шинээр худалдан авсан суурилуулж, бүтээгдэхүүний зузаан тодорхойлох, дулааны үзүүлэлт тодорхойлох багажуудын ашиглалтад оруулсан.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p>4.6. Ноолуурын өртгийн сүлжээнд хамрагдсан үйлдвэрлэл, худалдааг бүртгэлжүүлэн нэхмэлийн үйлдвэрлэлийг парк, кластераар хөгжүүлэхийг дэмжих.</p>
--	--	---

		<p>УИХ-аар 2019 оны 3 дугаар сард баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.1.4 заалтад “ноос, ноолуур”-ыг нэмж оруулсан. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь ноос, ноолуурын үйлдвэрүүдэд ялангуяа кластераар ажиллаж буй үйлдвэрүүдэд татварын таатай орчныг бий болгож байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p> <p>4.7. Ноолуурын үйлдвэрийг 3 жил тутамд аттестатчлах замаар шаардлагатай техник, технологийг шинэчлэх, үйлдвэрийг өргөтгөх.</p> <p>Ноос, ноолуурын үйлдвэрүүдэд техник, технологийн түвшний үнэлгээ хийх нээлттэй тендерт “Монголын ноос, ноолуурын холбоо” шалгарч, үнэлгээний баг 4 хэсэг болон ажилласан. Аттестатчиллаар ноос, ноолуурын үйлдвэрүүдийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа, техник технологи тоног төхөөрөмжийн судалгааг тус тус хийсэн. Судалгааг угаах, хялгас ялгах, ээрэх, сүлжих, нэхэх үйлдвэрлэл дээр хийсэн байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p>
Зорилт 4-ийн дундаж үнэлгээ – 74.3%		
	<p>5-р зорилтын хүрээнд: Салбарын хүний нөөцийг эрэлт, шаардлагад тулгуурлан сургаж, мэргэшүүлэх замаар үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх</p>	<p>5.3. Үйлдвэрүүд гадаад дахь ижил төрлийн үйлдвэртэй мэргэжилтэн солилцох хэлбэрээр олон улсын техник, технологийг судлах, туршлага хуримтлуулах ажлыг зохион байгуулах; (Олон улсад туршлага судлах, ажилтнуудыг мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулагдсан байна.)</p> <p>ШУТИС-ийн УТС, Бизнесийн удирдлагын сургуультай хамтран “Хөнгөн үйлдвэрлэл-тогтвортой ажлын байр -хүний нөөц” онол практикийн бага хурал 2019 оны 03-р сарын 25 нд зохион байгуулсан. Тус бага хурлаар элсэгчид, төгсөгчдийг хэрхэн татах болон тогтвор суурьшилтай ажиллуулах, мэргэжилтэй ажилтан бэлтгэх тактик, үйлдвэр-сургалтын байгууллагын уялдаа, мэдээллийн нэгдсэн санг хэрхэн бий болгох зэрэг асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлсэн.</p> <p>Хөнгөн үйлдвэрийн 85 жилийн хүрээнд 9 салбараас хүний нөөцийн бэлтгэл, тулгамдаж буй асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж, салбар бүрээс судалгаа авч нэгтгэсэн. Ноос ноолуур, арьс шир, оёдол, ой модны үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөн уулзалт, хэлэлцүүлгээс “Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлага, зөвлөмж гаргаж, хөтөлбөрийн төслийг танилцууллаа. “Үйлдвэржилт 21:100”, “Ноолуур” хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн суурь судалгааг үндэслэн хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдлын судалгаа хийв. МННХ, Шима Сейки компанийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран Японы Шима Сейки сүлжмэлийн бүрэн автомат машинаар үйлдвэрлэлээ явуулдаг компаниудын удирдлагуудыг Шима Сейки компанитай танилцуулах аяллыг зохион байгуулж, Шима Сейки дизайн системийн сургалт, танилцуулгыг хийв. Нийт 15 хүн оролцсон.</p> <p>АХБ-ны санхүүжилтээр Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнгийн Сорилтын төвийн итгэмжлэгдсэн лабораторид Японы JEOL фирмийн SEM багаж суурилуулж, тоног төхөөрөмжийг нийлүүлэгч талаас ХҮСХХ-ийн шинжээчдийг уг багаж дээр ажиллах чадвар эзэмшүүлэх сургалтыг явуулсан.</p> <p>Монголын радиогийн “Үйлдвэржилтийн цаг” хөтөлбөр болон Монголын үндэсний телевизийн “Өглөөний зочин” зэрэг нэвтрүүлгээр ноолуурын салбарын үйлдвэрлэлийн үйл ажиллагааны онцлог, ололт амжилт болон хөтөлбөр, түүний хэрэгжилтийн явцын талаар олон нийтэд сурталчлах ажлыг хийсэн. Мөн фэйсбүүк, болон ХХААХҮЯ-ны вэбсайтад цаг үеийн мэдээллүүдийг оруулж, олон нийтэд мэдээлэх ажлыг хийж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p>
Зорилт 5-ын дундаж үнэлгээ – 70.0%		
7.	<p>Дүгнэлт (ололт, дутагдал, асуудлууд) анхаарах</p>	<p>1. “Ноолуур” хөтөлбөрийн 2019 оны жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний ерөнхий дундаж 78.1 хувь буюу “Годорхой үр дүнд хүрсэн” гэсэн үнэлгээгээр дүгнэгдэв.</p> <p>2. ХХААХҮЯ-наас бодлогоор дэмжиж МУХБ-тай хамтран ажиллаж, гэрээ байгуулснаар ноолуурын үйлдвэрлэлийг дэмжихээр эргэлтийн хөрөнгийн 86.9, АХБ-наас хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” төслөөс 8.2 тэрбум төгрөгийн зээл олгосноор самнах үйлдвэрлэлийн хүчин чадал 40.0, ээрэх үйлдвэрлэлийнх 35.0, сүлжих үйлдвэрийн хүчин чадал 60.0 хувиар тус тус өсч, ажлын байрны тоо өмнөх оны хэмжээнд байна.</p> <p>3. Ноолуур боловсруулах салбарын түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 25.2 хувьд хүрч, суурь онтой харьцуулахад 36.0%-д хүрч, 3 дахин өссөн байна.</p> <p>Хөтөлбөрийн I шатанд (2018-2019он) “Нийт түүхий эдийн 40 хувийг дотоодын үйлдвэрийн хэрэгцээнд авч бэлтгэх” гэсэн зорилт 63.0 хувьтай хэрэгжсэн байна.</p> <p>Хангалттай хэмжээнд хүрээгүй шалтгаан: -МУХБ нь үйлдвэрүүдэд зээлийн дэмжлэг үзүүлж байгаа хэдий ч 2019 онд олгох зээлийг түүхий эд бэлтгэлийн үе дууссаны дараа хугацаа алдаж олгосон. Зээлийн хэмжээ өмнөх оноос 101.3 тэрбум төгрөгөөр буурч олгогдсон. Мөн зээлийн хүү өндөр, богино хугацаатай байсан нь үйлдвэрүүдэд бодит дэмжлэг болоогүй.</p>

		<p>- Хятад ченжүүд малчдаас ноолуурыг өндөр үнээр авснаас дотоодын үйлдвэрүүд түүхий эдийн хомсдолд орсон нь нөлөөлсөн. Ололттой тал:</p> <p>- Сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлт нь хөтөлбөрийн 2021 онд хүрэх шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшнээс 18.2 хувиар нэмэгдсэн байна.</p> <p>- “Монголын хаан ширхэгт” сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний чанарын стандартыг шинээр боловсруулан СХЗГ-ын ноос, ноолуурын стандартчлалын техникийн хороогоор хэлэлцүүлэн батлуулсан.</p> <p>- Гадаадын төслүүд нь үйлдвэр аж ахуйн нэгж, хоршоодтой хамтран сургалт, судалгаа, туршилтын ажлуудыг орон нутагт, үйлдвэрлэл дээр зохион байгуулсан нь мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх, чадавхижуулахад чухал нөлөө үзүүлсэн. Дутагдалтай тал, тулгамдсан асуудал:</p> <p>-ҮСХ-ноос гаргаж буй мэдээгээр ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, борлуулалтын мэдээ нэр төрлөөр гардаггүй тул хөтөлбөрийг дүгнэхэд хүндрэлтэй байна.</p> <p>-Үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх чиглэлээр тодорхой ажил хийх шаардлагатай.</p>						
8.	Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Хөтөлбөрөөс СЯ, ГХЯ, БОАЖЯ, МУХБанк, Монголын ноос, ноолуурын холбоо, олон улсын төсөл /ШХА-ийн Ногоон алт, малын эрүүл мэнд төсөл, АХБ-ны Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл, Дэлхийн банкны Экспортыг дэмжих төсөл, НҮБ-ын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл/, үйлдвэрлэгчид, Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн зэрэг хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын уялдаа холбоог “Хангалттай” гэж үнэлж байна.						
9.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилгын тоо	Зорилг 1	Зорилг 2	Зорилг 3	Зорилг 4	Зорилг 5
		78.1%	5	83.8	85	77.5	74.3	70
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ ... %						

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ (2019 оны жилийн эцсийн байдлаар)

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2017 он)	2018 оны гүйцэтгэл	2019 оны гүйцэтгэл	Зорилгот түвшин (2021 он)
1.	Угаасан ноолуурын экспорт	тн	5409.7	5286.6	5688.7	2632
2.	Самнасан ноолуурын экспорт	тн	571.4	630.2	507.2	1579
3.	Сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлт	мян.ш	915.6	2100.0	2600	2200
4.	Ажлын байрны тоо (байнгын)	хүн	5582	7126	7126	9110

ЗӨВЛӨМЖ

1. Цаашид ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг эрчимжүүлж, санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт суулгаж батлуулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх,
2. Хөгжлийн банкттай хамтын ажиллагаагаар сайжруулж, үйлдвэрлэгчдэд эргэлтийн хөрөнгийн зээлийн дэмжлэгийг ноолуур бэлтгэлийн хугацаанаас өмнө олгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх,
3. Угаасан ноолуурын экспортыг бууруулах чиглэлээр бодитой арга хэмжээ авах.
4. Хөнгөн үйлдвэрийн /ноос, ноолуур, арьс шир, оёдол г.м/ салбарын бодит статистик мэдээлэлтэй болох чиглэлээр ҮСХ-той хамтран ажиллах,
5. Салбар хариуцсан мэргэжлийн боловсон хүчнийг яаралтай авч ажиллуулах,
6. Хөнгөн үйлдвэрийн нэгдсэн мэдээллийн сантай болохыг ХҮХБХЗГ-т зөвлөж байна.